



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/35

Мандалговь

Зөвлөл байгуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 19.1 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1, 120.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: П.Оюунчимэг (Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ё.Цэцэгэлзий (Статистик мэдээллийн мэргэжилтэн)

Гишүүд: Б.Уранбайгаль (Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн)

Ч.Мөнхжаргал (Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

М.Отгонжаргал (Сахиул)

2. Албан хаагчдын ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулж жил бүр төлөвлөгөө гарган батлуулж ажиллахыг зөвлөлийн дарга (П.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.АЛТАНТӨГС